



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№47 /261/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.10

Цаг үе, үйл явдал

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАГДСАН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДАА ЭРГЭЛЭЭ



### Говь-алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар 2021 оны хоёрдугаар ээлжээр татагдан Зэвсэгт хүчний 256, 339 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдаа эргэж, ар гэрийнхэнтэй нь уулзалт зохион байгууллаа.

Батлан хамгаалахын сайд аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хааж буй

дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт хүүхдүүдийнх нь алба хааж буй анги салбарын орчин нөхцөл, өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт бэлтгэлийг танилцуулсан.

Тус үйл ажиллагаанд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Даваадорж, аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Цэргийн штабын бүрэлдэхүүн болон бусад албаны хүмүүс, хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийнхэн оролцлоо.

Ахмад Г.МӨНХБАЯР

## “МАРШ-ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН АВАРГА”-ААР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАГ ШАЛГАРАВ



### Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

“Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 101 жил, Халхын голын байлдааны ялалтын 83 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын нэрэмжит Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулсан “Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга” тасаг шалгаруулах тэмцээний аваргууд тодорлоо.

Уг тэмцээн нь Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд болов.

Тэмцээнд төрийн цэргийн болон хууль сахиулах зургаан байгууллагын эрэгтэй 14 тасаг оролцсоноос Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн ахлагч Б.Билгүүн ахлагчтай 2 дугаар тасаг, Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 56 дугаар ангийн ахлагч Я.Энхбаяр ахлагчтай 1 дүгээр тасаг, Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн ахлагч ахлагч Б.Лхагва-Эрдэнэ ахлагчтай 1 дүгээр тасаг, Дотоодын цэргийн 816 дугаар тусгай салбар, аймгийн Цагдаагийн газар тус тус бусдыгаа манлайлж, медальт байруудад шалгарлаа.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,271,860 /69.8%/	2,173,366 /66.8%/	1,026,782 31,6%
		107,441 /3,3%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8392 +112	71	8201

## ОЛНЫ ТАЛАРХЛЫГ ХҮЛЭЭСЭН БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



### Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн нийт эмэгтэй цэргийн алба хаагчид “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан олон бүтээлч ажлууд зохион байгууллаа.

Энэ хүрээнд гурван алба хаагчийн өндөр настай азай буурал ээжүүдэд хүндэтгэл үзүүлж гарын

бэлэг өгөхөөс гадна ахлах дэслэгч Б.Баасанжав даргатай үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн баярын аялгуу эгшиглүүлсэн нь тэдний сэтгэлийг маш ихээр хөдөлгөсөн юм. Тодруулбал, ангийн хүний нөөцийн офицер, ахлах дэслэгч Б.Цэцэгсүрэнгийн хадам ээж П.Норжин 86 настай, салааны ахлагч-тасгийн захирагч, ахлах ахлагч Ж.Отгонбаярын хадам ээж Б.Пүрэв 85 настай, Н.Сарантуяагийн ээж Индэр 84 настай юм.

### Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



## МОНГОЛ ЦЭРЭГ ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСЭД ОРОЛЦСОНООРОО НЭР ХҮНДЭЭ УЛАМ ӨСГӨЖ ЧАДСАН

### Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Тус анги удахгүй болох “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 101 жил, Монгол цэрэг энхийг сахиулах үйлсэд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан соёл хүмүүжлийн болон иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж байна.

Тухайлбал, энэ сарын 4-ний өдөр Ерөнхий боловсролын 26 дугаар дунд сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах бусад ажиллагаануудын онцлогийн талаар тус ажиллагаануудад үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчид мэдээлэл өгч, сурагчдын сонирхсон

асуултад хариуллаа.

Сурагчид танилцуулгын дараа “Монгол цэргийг олон улс тэр чигтээ хүлээн зөвшөөрсөн байна. Энэ нь Чингисийн удамт баатарлаг хөвгүүд гэхээс илүү яг өнөөдрийн гүйцэтгэж байгаа үүрэг, ур чадвар, сахилга хариуцлага, эр зоригор нь ингэж дүгнэж байна гэж бид ойлгосон. Энэ бол энх цагийн хамгийн том амжилт. НҮБ-ын гишүүн орны хувьд ч монгол цэргүүдийн гүйцэтгэж байгаа үүрэг Монгол Улсын нүүр тахлах гол ажил нь байдаг гэдэгт нь ч эргэлзэхгүй байна” хэмээгээд цэргийн ах, эгч нараараа үргэлж бахархсаар байна гэв. Сургалтын төгсгөлд ангийн Үлээвэр найрал хөгжмийн салааныхан сурагчдад зориулж хэсэгчилсэн тоглолтыг толилууллаа.

Дэслэгч Б.БАТТУЛГА



## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 451,740,204

Эдгэрсэн  
Нийт: 385,808,646

Нас барсан  
Нийт: 6,043,698

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
-3	-12


ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
42	28

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,890.00	2,905.0
EUR	3,160.0	3,180.0
CNY	456.00	457.50
RUB	24.00	28.00
JPY	24.95	25.10
KRW	2.41	2.42

## ЗУРХАЙ



2022.03.10 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР НОХОЙ ӨДӨР

### Үс засуулбал:

НАС УРТАСНА  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.16-18.49  
БАРИЛДЛАГА:  
Хотол чуулган  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
САНСАР  
Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

## МЕНИНГИТ ӨВЧИН

МЕНИНГИТ нь менингококкоор үүсгэгдэх маш богино хугацаанд хүчирхэг эрсдэлтэй халдварт өвчин.

Агаар дуслын замаар болон бохир гар, хүнсний зүйлсээр дамжин халдварладаг.

Бала насны хүүхдэд өртөх эрсдэл илүү өндөр байдаг.

ИЛЭРХ ШИНЭ ТЭМЦЭГ	СРЬЛЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГАЧЛАЛ
ГЭСЭТ ӨНӨР ХАЛДВАР	НИЙР ХОЛДОН ЦЭРЭГ БЭЛЭГНЭГ ҮРЭВЭЙГ СЭРГЭЛТЭЙ ЭРГИЙН ЗАРЫВ ДАСАЛТЭРЭГ ЭМЧИЛЭХ
ӨӨРӨНХ	ЭГЭВЭЭСЭН ДЭЛХИЙ ЭРГИЙН ХАМГААГАХ АРГАЧЛАЛ
СЭЛЭГ	МЕНИНГОКОК ХАЛДВАРЫН СЭРГЭЛТЭЙ ЭРГИЙН ХАМГААГАХ АРГАЧЛАЛ
ХСРЛЭГЭЛ, ДЭМЖЭЭГ ЭРЭГТ	ЭРЭГ ТАСЛАГАЛ
ЦЭСЭРЛЭГ ТЭРЛЭГ	ЭРЭГ ТАСЛАГАЛ
ТӨЛӨГ ҮЕ МЭРГЭЭГ ХҮҮТЭЙ ӨВЧИН	ЭРЭГ ТАСЛАГАЛ
КОЛОН ДЭРГИЙ ӨВЧИН	ЭРЭГ ТАСЛАГАЛ

О-5 НАСНЫ ХҮҮХДҮД ҮГ ХАЛДВАРААР ӨВЧӨНД ХОЛДОНД МАШ ХУРДАН ХИЧЭЭРДЭГ ТУЛ ЦАГ АЛДАЛГУЙ ЭМНЭЛЭГТ ХАНДАГАЙ!

Цахим шууданд

## ДАЙЧИД СУРГАЛТАД ХАМРАГДАВ



“Хүн өөрийнхөө гараар баялгийг бүтээж чаддаг гэдгийн тод илрэлийг тус ангийн хугацаат цэргийн алба хаагчид үйлдлээрээ харуулж, бусдад зөв үлгэр дуурайлал үзүүлж байгаа нь сайшаалтай хэрэг боллоо” гэж онцлон хэлсэн юм.

Уг сургалтаар байлдагч нар гутлын эсгүүр, хэвлэгээ, хээ угалз гаргах, уллагаа, оёдол, цаг агаарын ямар ч нөхцөлд эдэлгээ даах чадвартай материал сонгох гээд олон нарийн зүйлийг суралцсанаас гадна тэр дундаа хувь хүний манлайлал,

### Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн хугацаат цэргийн алба хаагчид нэг сарын өмнө цагаан ултай гутлыг оёж сурах сургалтаа эхлүүлж байсан бол өнөөдөр юу сурч мэдсэнээ онжавууддаа болон ангийн удирдлага, хамт олондоо тайлагнав.

Сургалтын сургагч багшаар тус ангийн зочид буудлын эрхлэгч энгийн Ж.Нарансолонго ажилласан юм. Сургалтад байлдагч Г.Лхагвасүрэн, А.Дашранзад, Б.Отгонбилэг, Б.Баянпүрэв, ИсапРот байлдагч Г.Дашням, Х.Буяннэмэх, Б.Нямцогт, Х.Нямдалай, Ж.Дашзэвэг, Б.Дэмбэрэлдорж нар хамрагдсан билээ.

Энэ үеэр байлдагчид хэлэхдээ сургалтын явцад зүүгээр хурууны өндгөө нэг бус удаа хатгах зэрэг асуудал гарч байсан. Гэсэн ч хичээнгүйлэн суралцсаны үр дүнд өрхийн орлогоо нэмэгдүүлэх, цаашид



орон нутгийнхаа хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах боломжтой боллоо. Сургалтыг зохион байгуулсан ангийн удирдлага болон сургагч багшдаа баярлалаа гэж хэлсэн юм.

Сургалтын төгсгөлд ангийн удирдлага байлдагч нарт хандаж хэлсэн үгэндээ

аливаа зүйлд тууштай байх зан чанар, тэсвэр хатуужил, тэвчээр, хамт олон болон бүлгийн оролцоо ямар чухал вэ? гэдгийг давхар давхар суралцсан онцлог сургалт боллоо.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

## ГЭМТ ХЭРЭГ ОСОЛ ЗӨРЧЛИЙН ТАЛААР СУРГАЛТ ОРОВ

### Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Ангийн 2021-2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албатай хамтран ажиллалаа.

Энэ хүрээнд тус албаны урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Д.Ганхуяг бие бүрэлдэхүүнд “Цахим гэмт хэрэг”, “Зам тээврийн осол, зөрчлийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замууд”, “Ажлын байран дээрх архидалт, түүнийг таслан зогсоохтой тэмцэх” сэдвээр сургалт явуулж, гэмт хэрэг, ослын шалтгаан, нөхцөлийг тайлбарлаж, заавар, зөвлөмж өгч, бие бүрэлдэхүүнээс



тавьсан асуултад хариулж, мэдээллээр хангасан үр

дүнтэй сургалт зохион байгуулагдлаа.

Ахмад Б.НАРАНБААТАР

## “ЭХ ОРНЫ ЦЭРЭГ-2022” ЯРУУ НАЙРГИЙН НААДМЫН УДИРДАМЖ



### Нэг. Зорилго

Монгол Улсын Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 111 жилийн ой, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой, Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд цэрэг эх орны сэдэвт яруу найргийн өв санг баяжуулах, цэргийн алба хаагчид, ард иргэд, хүүхэд залуучуудад төрөлх нутаг, тусгаар тогтнол, түүх соёлоороо бахархах сэтгэлийг төрүүлэх, цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, яруу найргийн шилдэг бүтээлүүдийг сурталчлан нийтийн хүртээл болгоход оршино.

### Хоёр. Хугацаа

1. I шатны шалгаруулалтыг 2022 оны 03 дугаар сарын 13-ны өдөр,
2. II шатны шалгаруулалтыг 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд тус тус зохион байгуулна.

Гурав.Тавигдах шаардлага  
Наадамд ирүүлэх шүлгүүд нь цэргийн сэдэвтэй, яруу найргийн наадамд уншигдаж байгаагүй шинэ бүтээлүүд байна. Уралдаанд оролцох яруу найрагчид цэргийн сэдэвт 2 шинэ бүтээлээ 2022 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 16.00 цаг хүртэл ЦДБЭЧ-ын 205 тоотод бүртгүүлж, оролцох эрхийн мандат авна. /Мандатын үнэ 10.000 төгрөг/ Дэлгэрэнгүй мэдээллийг 89074727 дугаараас тодруулах боломжтой.

### Дөрөв. Наадмын зохион байгуулалт

Наадмын I шатанд ирүүлсэн бүтээлүүдийг шүүгчдийн бүрэлдэхүүн хэлэлцэж, II шатанд 20 яруу найрагчийг шалгаруулна.

II шатанд шалгарсан яруу найрагчид 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 3 үе шаттайгаар шүлгээ уншиж, шилдгээ тодруулна.

Яруу найрагчдыг үе бүрд онооны дарааллаар хасагдах байдлаар шалгаруулна.

### Тав. Шагнал

Амжилттай оролцсон бүтээлийг дараах байдлаар байр эзлүүлэн урамшуулна.

- Тэргүүн байр – 1 /Өргөмжлөл, 1,000,000 төгрөг, Жанжны сэлэм/
- Дэд байр – 1 /Өргөмжлөл, 700,000 төгрөг/
- Гуравдугаар байр - 1 /Өргөмжлөл, 400,000 төгрөг/
- Тусгай байр - 1 /Өргөмжлөл, 200,000 төгрөг/

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД АХЛАГЧ НАР ИДЭВХТЭЙ ОРОЛЦЛОО



### Зэвсэгт хүчний 326 дугаар анги

“Ахлагчийн албаны хөгжил, хэтийн төлөв” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын 1 дүгээр шатны Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн ахлагчийн зөвлөл амжилттай зохион байгуулж явууллаа. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний ахлагчийн албаны туршлага, сургамж, үйл ажиллагаа, хэтийн төлөвийг шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой чиглэлийн хүрээнд судалж, үр дүнг тооцож зорилгоор зохион байгуулж буй

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРӨӨР ...



### Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүн “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан нийт эмэгтэйчүүдээ гэнэтийн бэлэг барилаа. Тухайлбал, ангийн удирдлага, эрэгтэй цэргийн алба хаагчдын зүгээс эмэгтэйчүүдээ гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулж, эмэгтэйчүүдийн дунд “Гар бөмбөг”, “Асуулт хариулт асуулт”-ын тэмцээнийг зохион байгуулсан бол тус арга хэмжээний үеэр ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс шилдэг 2 азанг шалгаруулж зөвлөлийн нэрэмжит шагналаар шагнаж урамшууллаа.

Ахмад З.АНХБАЯР

### Зэвсэгт хүчний 325 дугаар анги

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн ангийн удирдлага болон нийт эрэгтэйчүүдийн зүгээс бүх бүсгүйчүүдээ баяр хүргэж, дурсгалын зүйл гардуулж, босоо хүлээн авалтын арга хэмжээ зохион байгууллаа. Мөн энэ үеэр Сургалт, соёл хүмүүжлийн албанаас бэлтгэсэн урлагийн тоглолт болон Завхан аймгийн “Цагаан чулуут” сумын харьяат СТА Пүрэвхүүгийн Бат-Ундрах ангийн захирагч хурандаа Г.Чулуунзагдын урилгаар хүрэлцэн ирж нийт эмэгтэйчүүдэд ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Ахмад Н.МӨНХБААТАР

